

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлд:

“ХҮҮ.2.ХЭЛЭЛЦСЭН нь: Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Засгийн газраас санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган болон Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэх үед сайд нар тогтмол оролцож, хариуцсан асуудлаараа Улсын Их Хурлын гишүүдэд холбогдох тайлбар, мэдээлэл өгч байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.


2. Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголпросцветмет” ХХК-ийн талаар Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилтийн явц байдлын талаар Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд мэдээлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгав.

3. Засгийн газрын 2016 оны 36 дугаар тогтоолоор байгуулагдсан Ажлын хэсгээс Монгол Улсын Хөгжлийн банкинд хийсэн хяналт шалгалтын дүнг Засгийн газрын гишүүдэд хүргүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтод, хяналт шалгалтын дүнтэй танилцан өөрийн эрхлэх ажлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээ бүрээр судалгаа, дүгнэлт гаргаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхийг холбогдох сайд нарт тус тус даалгав.

4. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төрөөс олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасгах, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгах арга хэмжээний хүрээнд тусгай зөвшөөрлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар ойрын хугацаанд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллага, шинжээч, эрдэмтэн, иргэн, хуулийн этгээдийн дунд хэлэлцүүлэг хийж саналыг нь авч, холбогдох хуулийн төслийг боловсруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, холбогдох сайд нарт даалгав.

5. Засгийн газрын гишүүд өөрийн эрхлэх ажлын хүрээнд ойрын хугацаанд авч хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байгаа томоохон хоёроос доошгүй төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг бэлтгэн Ерөнхий сайдад танилцуулж, ажлын уялдааг хангаж ажиллахыг холбогдох сайд нарт даалгав.

6. Бүтээн байгуулалтын улирал эхэлж байгаатай холбогдуулан улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2017 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс мөн оны 7 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга нар гадаадад томилолтоор явах асуудлаа хойшлуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР